



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/258

Мандалговь

Мал угаалгын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1, 21.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шимэгчтэх өвчний гаралт тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор мал угаалгын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Угаалгад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

3. Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, зааврын дагуу технологит хугацаанд нь мал сүргийг угаалгад бүрэн хамруулж, чанартай гүйцэтгэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанартай эмийн бодис ашиглан үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



481210006

Аймгийн Засаг даргын 2021
оны 07 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/2558 дугаар захирамжийн хавсралт

Угаалгын арга хэмжээнд хамрагдах
малын тоо

№	Сумын нэр	Малын тоо		
		Хонь	Ямаа	Үхэр
1	Сайнцагаан	184705	179003	
2	Адаацаг	130098	122123	
3	Баянжаргалан	79772	59206	
4	Говь-Угтаал	100910	82712	500
5	Гурвансайхан	163702	119444	
6	Дэлгэрхангай	57993	89119	
7	Дэлгэрцогт	83200	79600	
8	Дэрэн	130797	112070	
9	Луус	65000	65000	1000
10	Өлзийт	146484	158672	
11	Өндөршил	92558	75727	2025
12	Сайхан-Овоо	75514	85193	
13	Хулд	119600	117200	
14	Цагаандэлгэр	55000	43000	
15	Эрдэнэдалай	256942	225227	18126
Нийт дүн		1742275	1613296	21651